

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/20

Өлгий

Г Өндөр тунт А аминдэмийн тухай батлах тухай Г

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/167 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн түвшинд 6 сараас 5 хүртэлх насны хүүхдэд “Өндөр тунт А аминдэм түгээх хуваарь”- ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Хуваарийн дагуу өндөр тунт А аминдэмийг харьяа нутаг дэвсгэрийн 06 сараас 5 хүртэлх насны хүүхдэд халдвар хамгааллын дэглэмийг сахин түгээлт хийж, тайланг Эрүүл мэндийн сайдын 2020 оны 490 дүгээр тушаалын дагуу аймгийн Эрүүл мэндийн газарт ирүүлэхийг сум дундын эмнэлэг, сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нарт даалгасугай.

3. Бага насны хүүхдийн дархлааг дэмжих, хоол тэжээлийн дутал, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалт, сурталчилгааг иргэдийн дунд тасралтгүй зохион байгуулж, мэргэжлийн зөвлөгөө, мэдээллээр хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газрын хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан ажилтан /Т.Рахат/- д даалгасугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга /Е.Сауле/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Н.САКЕН





Өндөр тунт А аминдэмийг 5 хүртэлх насны хүүхдэд түгээх хуваарь

№	Сум, өрх	6-11 сартай хүүхэд		12-59 сартай хүүхэд		Хүлээн авсан хүний нэр, гарын үсэг
		Хүүхдийн тоо	100,000 ОУН	Хүүхдийн тоо	200,000 ОУН	
1	Алтай	42	45	414	430	
2	Алтанцөгц	28	30	291	300	
3	Баяннуур	46	46	397	410	
4	Бугат	47	50	102	110	
5	Булган	48	50	539	570	
6	Буянт	37	40	280	300	
7	Дэлүүн	107	110	1211	1220	
8	Ногооннуур	93	95	848	890	
9	Сагсай	61	61	882	900	
10	Толбо	57	60	581	600	
11	Улаанхус	116	120	951	990	
12	Цэнгэл	150	156	1105	1150	
13	Цагааннуур	20	20	215	220	
14	Хотгор	7	7	113	120	
15	Жансая	166	170	1146	1200	
16	Мейрим	240	240	1543	1600	
17	Рауан	95	95	474	500	
18	Шипагер	180	180	1042	1090	
19	Нийт	1540	1575	12 134	12 600	

Тайлбар:6-11 сартай хүүхдэд 200 000 ОУН А аминдэмийг Эрүүл мэндийн сайдын 2020 оны 490 дүгээр тушаалын дагуу ½ капсул (3 дусал)-ыг 100 000 ОУН-ээр тооцон, уулгана.

Хуваарь гарагсан: ЭМГ-ын Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Т. Рахат